

**Товч танилцуулга**
СОД ГАЗАР ХХК болон ГЕО ЭРИН ХХК-ий хоорондын ажил гvйцэтгэх гэрэний дагуу 2009-2010 оны хугацаанд Хох толгойн жонжны ордод нарийвчилсан хайгуулын ажил явуулж нооцийн тооцоог хийж гvйцэтгэсэн.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО
Сод газар компаний гол зорилго нь Хох толгойн жоншны ордын хэмжээнд илэрсэн метасоматит гаралтай хайлуур жоншны тархалтыг тогтоох, нооцийг тогтоон улмаар ашиглалтанд бэлтгэх зорилготой байсан.

## ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН СТАТУС
Хох толгойн хайгуулын тусгай зовшоорол нь Сод Газар ХХК-ий омч богоод дугаар нь 9964X, талбайн хэмжээ нь 1960 га. 2005 оны 6 сарын 8-нд Сод Газар ХХКед олгогдсон. 2014 он хvртэл сунгагдах боломжтой.

## ДЭД БҮТЭЦ
Хох толгойн талбай нь Улаанбаатараас зvvн зvгт 600 км орчим, Сvхбаатар сумаас зvvн зvгт 70 км орчим, Хоотийн нvvрсний уурхайгаас баруун зvгт 18 кмт алслагдсан. Үvнээс 380 км нь хатуу хучилттай зам юм.

## НӨӨЦИЙН ТООЦООНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ
Хох толгойн жоншны ордын нооцийн тооцоог 0.5 метрээс зузаантай хvдрийн биетvvдийн хэмжээнд болон сэвсгэр хурдсан дахь хуримтлалын хэмжээнд тооцон гаргасан. Боломжтой нооцийн хэмжээг 30.6% $CaF_2$ агуулга бvхий хvдрээр 1'366'237.60 тонн гэж тооцоолсон богоод 417'835.6 тонн 99.99% $CaF_2$ агуулга бvхий цэвэр жоншийг гарган авна гэж тооцоолсон. Хvснэгт 3. Хvдрийн биетийн хэмжээнд 30% $CaF_2$ агуулгаас бага агуулгатай хvдрийг тооцоолоход 586'670 тонн хvдэр тогтоогдсон богоод нийт энэ хэсгийн цэвэр жоншний хэмжээг тооцоолоход ордын хэмжээнд 25.1% $CaF_2$ дундаж агуулга бvхий 147'077 тонн цэвэр жонш тогтоогдоно.

Хvснэгт 3. Нооцийн тооцооны нэгтгэл

-ээс

хvртэл

Хvдрийн эзлэхvvн ( м $^{3}$ )

Хvдрийн хэмжээ, тонн

Эзлэхvvн жин

Хайлуур жоншны дундаж агуулга

Тухайн интерваль дахь цэвэр жоншны хэмжээ, тонн

0

30

209525

586670

2.8

25.0698

147076.9957

30

<

278417

779567.6

2.8

34.7319

270758.6393

TOTAL

487942

1366237.6

30.5829

417835.6349

1. 0.5 м-ээс зузаантай биетvvдийн хэмжээнд нооц тооцоолсон. 2. Дундаж эзлэхvvн жин 2.8 тн/м3. 3. Тоон утгуудын бутархай орны зарим нэгжийг шилжvvлэн авсан. 4. Нооцийн тооцоог хийхэд агуулга тархаахдаа Урвуу Зайн Хамаарлын аргыг ашигласан. 5. Бодитой нооцийн хэмжээг тооцоолоход хайлтын радиусын утга 100X50X10 м ба Боломжтой нооцийн хэмжээг тооцоолоход 300X150X50 м-ийн радиусаар хайлт хийгдсэн.

## НЭМЭЛТ ХАЙГУУЛ ХИЙХ ПОТЕНЦИАЛЬ

Хох толгойн ордын хэмжээнд нооц тооцоолсон хэсгээс зvvн тийш хоорондоо параллель хэд хэдэн биетvvд тогтоогдсон богоод энэ хэсэгт нэмэлт хайгуул хийхэд хэтийн толовтэй юм. Энэхvv хэсгийн урт нь 1000 м орчим богоод таамагласан баялагийг 30.6% гэсэн дундаж агуулга бvхий 5'589'645.61 тонн хvдэрт 1'710'431.557 тонн цэвэр жонш тогтоогдох боломжтой гэж тооцоолсон.



Нооц тооцсон хэсэг (улаан, ногоон, шар) болон таамагласан баялаг тооцоолсон хэсэг (ягаан).